

САЙДЫН ТУШААЛ

20... оны ... сарын ... өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх  
журам батлах тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнийг тандах хэлбэрүүд”-ийг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн ерөнхий газар ()-т даалгасугай.
3. Энэхүү журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс (...) -т үүрэг болгосугай.

САЙД

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн  
сайдын 2023 оны ... дүгээр сарын .... -ны  
өдрийн ..... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

## **Мал, амьтны халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх журам** **Guideline on animal diseases surveillance and reporting**

### **Нэг. Нийтлэг үндэслэл (Background)**

1.1. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, шийдвэр гаргахад шаардлагатай нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллийг бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Тандалтын үр дүнд үндэслэн мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, устгах, хариу арга хэмжээг шуурхай, оновчтой зохион байгуулах, эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай суурь тоон мэдээлэл, баримт бүрдүүлэх, мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлын баталгаажуулалтыг хангах үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Төрийн болон хувийн өмчийн бүх шатны мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний тандалтын мэдээ, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх, эргэн мэдээлэх болон мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангах, шийдвэр гаргахад шаардагдах нотолгоонд суурилсан мэдээллийг бүрдүүлэхэд халдварт өвчнийг тандах, үр дүнг мэдээлэх журмыг (цаашид “журам” гэх) баримтална.

1.4. Тус журам нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалд заасан “Мал, амьтны гоц халдварт өвчнийг мэдээлэх журам”, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын 2022 оны А/177 дугаар тушаалаар баталсан “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын заавар” болон холбогдох бусад эрхзүйн актаас бүрдэнэ.

### **Хоёр. Зохион байгуулалт, хэрэгжилт (Implementation of the guideline)**

2.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн газар, лаборатори, Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, эрчимжсэн мал аж ахуй, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэгч байгууллагууд энэхүү журмыг хэрэгжүүлнэ.

2.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын Тархварзүйн асуудал хариуцсан нэгжийн дарга, Улсын мал эмнэлэг,

ариун цэврийн төв лабораторийн Тархварзүйн асуудал хариуцсан нэгжийн дарга, Мал эмнэлгийн газрын Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгжийн дарга, Мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч, ийлдэс судлалын шинжээч, Мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархвар зүйч, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч, аж ахуйн нэгжийн малын эмч журмын хэрэгжилтийг хариуцна.

2.3. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг нь халдварт өвчний тандалтын багтай байна.

2.3.1. Төвийн түвшний тандалтын багийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулна. Төвийн багийг тархварзүйн асуудал хариуцсан нэгжийн дарга ахалж, лаборатори, гоц халдварт өвчин, зооноз өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн ерөнхий эмч, тархварзүйн асуудал хариуцсан нэгжийн дарга тус тус байна.

2.3.2. Мал эмнэлгийн газрын халдварт өвчний тандалтын багийн бүрэлдэхүүнийг байгууллагын удирдлагын шийдвэрээр байгуулж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан нэгжийн дарга ахлах ба зооноз, халдварт өвчин, тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн эсвэл өвчний мэдээ, тайлангийн асуудал хариуцсан мэргэжилтэн, мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч, шинжээч эмч байна.

2.3.3. Мал эмнэлгийн тасгийн халдварт өвчний тандалтын багийн бүрэлдэхүүнийг Мал эмнэлгийн газрын дарга байгуулж, улсын байцаагч ахлах ба бүрэлдэхүүнд тархварзүйч, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, аж ахуйн нэгж, байгууллагын малын эмч байна.

### **Гурав. Халдварт өвчний тандалт хариуцсан байгууллага, нэгж, газар, багийн гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of organizations and surveillance teams)**

#### **3.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of GAVS on surveillance activities)**

3.1.1. Өвчин, халдваргүй болохыг баталгаажуулах тандалтад хамруулах халдварт өвчний жагсаалтыг гаргаж, тандалт хийх хугацааг урт болон дунд хугацаагаар нарийвчлан төлөвлөнө.

3.1.2. Жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан улсын тандалтын төлөвлөгөө, загварыг боловсруулж батална. Төлөвлөгөөний хэрэгжилтийг мал эмнэлгийн сүлжээ лаборатори, Мал эмнэлгийн газар, тасагтай хамтран зохион байгуулна.

3.1.3. Жилийн төлөвлөгөөнд тандалтын зорилго, хэлбэр, хамрагдах мэдрэмтгий мал, амьтны тоо, санхүүжилт, шаардагдах хүний нөөц, тоног төхөөрөмж, багаж

хэрэгсэл зэргийг тусгана.

3.1.4. Тухайн жилийн тандалтын зардлыг улсын төсөвт тусгаж, хэрэглэгдэхүүний нийлүүлэлтийг эхний хагас жилд багтаан тандалт явуулах орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад хүргэсэн байхаар тооцож, худалдан авалтыг зохион байгуулна.

3.1.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгж болон Мал эмнэлгийн газрын тандалтын багийг арга зүйн удирдлагаар хангах, халдварт өвчний дэгдэлтийн үед бие даан судалгаа хийх, шуурхай хариу арга хэмжээ авах, хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, тайлан боловсруулах, үр дүнг хэвлэн нийтлүүлэх талаар тасралтгүй сургалтад хамруулна.

3.1.6. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалтын баг нь гоц халдварт, халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх бодлогын бичиг баримт боловсруулахад шаардагдах нотолгоонд суурилсан зөв мэдээллийг тасралтгүй, системтэйгээр цуглуулах, бодлогын бичиг баримтын төсөл боловсруулах аргад сургаж, тархвар судлалын судалгааны аргууд дээр үндэслэн мал, амьтны халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлс, шалтгааныг тогтоох чадвар эзэмшүүлнэ.

3.1.7. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчин, хэрэгжүүлсэн тэмцэх, сэргийлэх арга хэмжээний мэдээллийг агуулсан олон жилийн тандалтын тоон мэдээний улсын цахим санг үүсгэнэ.

3.1.8. Мал, амьтны халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг тандалт судалгааны үр дүнд үндэслэн төлөвлөж, бодлогын бичиг баримтын төслийг боловсруулна.

3.1.9. Мал, амьтны халдварт өвчний тандалтын чиглэлээр салбар хоорондын болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

**3.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжийн халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the Epidemiological Department on information, training and advocacy of GAVS on surveillance activities)**

3.2.1. Тандалтын багт хамаарах гишүүн тус бүрийн тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг тодорхойлж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар батлуулна.

3.2.2. Халдварт өвчин, халдваргүй болохыг баталгаажуулах тандалтад хамруулах өвчин бүрд тохирсон сэжигтэй (suspected case), магадлалтай (probable

case), батлагдсан тохиолдол (confirmed case)-ын тодорхойлолтыг баталж, тандалтын мэдээ, мэдээлэл цуглуулахад ашиглана.

3.2.3. Улсын хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг өдөр тутамд, бүх халдварт өвчний батлагдсан тохиолдлын мэдээг сар тутамд цуглуулж, дүн шинжилгээ хийн, гоц халдварт болон эндемик халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.2.4. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалд заасан “Мал, амьтны гоц халдварт өвчнийг мэдээлэх журам”-ын дагуу гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг Мал эмнэлгийн газраас тухай бүр хүлээн авч, удирдлага, дээд шатны болон байгууллагын холбогдох мэргэжилтнүүдийг 1 цагийн дотор нөхцөл байдлын мэдээллээр хангана. Хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох Мал эмнэлгийн газрын тандалтын багийг шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж, эргэн мэдээллээр тасралтгүй хангана.

3.2.5. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын 2022 оны А/177 дугаар тушаалаар баталсан “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын заавар”-ын дагуу шүлхий, үхрийн арьс товруутах, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг зэрэг гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтын мэдээг өдөр тутамд Мал эмнэлгийн нэгдсэн системээс нэгтгэн, дүн шинжилгээ хийж мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах, Мал эмнэлгийн газрын тандалтын багийг эргэн мэдээлэл, мэргэжил, аргазүйн зөвлөмжөөр тасралтгүй хангах, мэдээ ирүүлэлтийн байдалд хяналт тавих, үнэлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ. Илрүүлсэн сэжигтэй тохиолдлын оношийн баталгаажилтын байдалд хяналт тавьж, дүгнэлт хийнэ.

3.2.6. Мал эмнэлгийн газрын тандалтын багаас мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй өвчнөөр олон мал, амьтан өвчилсөн талаарх мэдээлэл ирсэн тухай бүр МЭЕГ, УМЭАЦТЛ-ийн удирдлага, дээд шатны байгууллагын холбогдох мэргэжилтнүүдэд 2 цагийн дотор утас болон цахим хаягаар мэдээлж, ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, холбогдох Мал эмнэлгийн газрын тандалтын багийг шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, хамтран ажиллана. Холбогдох Мал эмнэлгийн газрын тандалтын баг болон Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, УМЭАЦТЛ-ийн удирдлага, ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтнүүдийг өдөр тутамд эргэн мэдээллээр хангаж, хариу арга хэмжээг зохион байгуулна.

3.2.7. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт, эпидемийн үед холбогдох Мал эмнэлгийн газрын тандалтын багаас мал, амьтны өвчлөл, хорогдол, хэрэгжүүлж буй шуурхай хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг өдөр тутамд цахимаар авч, дүн шинжилгээ хийж, шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил

аргазүйн зөвлөмжөөр тогтмол хангах, үр дүнг эргэн мэдээлэх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр тасралтгүй хангах ажлыг зохион байгуулна.

3.2.8. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын мэдээг Мал эмнэлгийн газрын тандалтын багаас сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон [survey@vet.gov.mn](mailto:survey@vet.gov.mn) хаягаар цахим хэлбэрээр авч, дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг сар бүрийн эхний 7 хоногт багтаан удирдлага, бусад холбогдох мэргэжилтнүүд, Мал эмнэлгийн газрын тандалтын багийн ахлагчид цахим хэлбэрээр эргэн мэдээлнэ. Эргэн мэдээлэлд улсын хэмжээнд халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх аргын талаар саналыг тусгана.

3.2.9. Мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын улсын хэмжээний тоон мэдээнд сар, улирал, хагас жил, жил тутамд дүн шинжилгээ хийж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бусад удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, Мал эмнэлгийн газрын тандалтын багийн ахлагчийг эргэн мэдээллээр тасралтгүй хангана.

3.2.10. Мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын олон жилийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, өвчин тус бүртэй тэмцэх, сэргийлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх, өвчлөлийн босго үзүүлэлт, хэтийн хандлагыг тооцох, тэргүүлэх чиглэл тогтоох замаар халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг зөв төлөвлөх, тохирсон хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийг бүрдүүлж, бодлого боловсруулахад ашиглана.

3.2.11. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор улсын хэмжээнд үйл явдалд суурилсан тандалтын мэдээллийг цуглуулж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.2.12. Жил тутамд 5 Мал эмнэлгийн газар, 20-30 Мал эмнэлгийн тасгийн халдварт өвчний тандалтын багийн үйл ажиллагаанд биечлэн хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.

3.2.13. Мал эмнэлгийн газрын тандалтын багийн үйл ажиллагаанд улирал, хагас жил, жил тутамд шалгуурын дагуу хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.

3.2.14. Улсын хэмжээний мал, амьтны халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд 2 жил тутамд зохих аргачлалын дагуу үнэлгээ хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

### **3.3. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the SCVL on surveillance activities)**

3.3.1. Улсын төлөвлөгөөт тандалтын нэгдсэн удирдамжийг боловсруулж Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаар батлуулан, мал эмнэлгийн сүлжээ лаборатори, холбогдох Мал эмнэлгийн газар, тасгуудтай хамтран тандалтыг зохион байгуулна.

3.3.2. Жил бүрийн эхний хагаст багтаан тандалт шинжилгээнд шаардагдах багаж, тоног төхөөрөмж, урвалж, оношлуур, шил сав, хэрэглэгдэхүүнийг тандалт явуулах орон нутгийн мал эмнэлгийн байгууллагад хүргэсэн байхаар худалдан авалтыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

3.3.3. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжээс мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй, өвөрмөц, онош тодорхойгүй өвчнөөр олон мал, амьтан өвчилсөн талаарх мэдээлэл ирсэн тухай бүр холбогдох Мал эмнэлгийн газрын тандалтын багтай холбогдож, халдварын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шалтгааныг тогтоох зорилгоор сорьц цуглуулж шинжилнэ. Шинжилгээний талаарх мэдээллийг өдөр тутамд Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан тандалтын багт тайлагнана.

3.3.4. Бүх түвшний улс, хувийн хэвшлийн мал эмнэлгийн лабораторид хийгдэж буй тандалт шинжилгээний мэдээлэлд тогтмол хяналт тавьж, мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний үүсгэгч илэрсэн тохиолдолд мэдээллийг баталгаажуулан, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжид 2 цагийн дотор мэдээлж, сорьцод баталгаажуулах шинжилгээ хийнэ.

3.3.5. Улсын хэмжээнд мал, амьтны халдварт өвчний тандалт шинжилгээг хийхдээ тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, эрэмбэлэн, шийдвэрлүүлэх саналаа Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шуурхай хүргүүлнэ.

3.3.6. Мал, амьтны халдварт өвчин тус бүрийн тандалтад хэрэглэгдэж байгаа лабораторийн шинжилгээний аргын хоорондын тохироо, оношлуур, урвалын мэдрэг, өвөрмөц чанарыг судлан, лабораторийн шинжилгээний оновчтой аргаар тандалтыг гүйцэтгэнэ.

3.3.7. Бүх түвшний мал эмнэлгийн лабораторид хийгдэж буй тандалт шинжилгээний баталгаажилтыг хянаж, улсын хэмжээнд дотоод чанарын хяналтыг хийнэ.

3.3.8. Тандалтаар цуглуулж буй сорьцыг хүлээн авах ба тээвэрлэлт, хадгалалтын

байдалд хяналт тавина.

3.3.9. Бүх түвшний лабораториос тандалт шинжилгээний мэдээллийг цуглуулж нэгтгэн, долоо хоног, сар, улирал, хагас жил, жил тутамд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, лабораторийг эргэн мэдээллээр хангана. Эргэн мэдээллийн хувийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын удирдлага болон холбогдох бусад мэргэжилтнүүд, Мал эмнэлгийн газрын тандалтын багийн ахлагчид цахимаар хүргүүлнэ. Эргэн мэдээлэлд улсын хэмжээнд халдварт өвчний тандалтын шинжилгээнд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын саналыг тусгана.

3.3.10. Өвчин, халдваргүй болохыг баталгаажуулах тандалт шинжилгээний тайланг тухай бүр бичиж, үр дүнг хэвлэн нийтлүүлэх ажлыг улсын хэмжээнд хариуцна.

3.3.11. Бүх түвшний лабораторид ажиллаж буй шинжлээч нарт тандалт шинжилгээний мэдээллийг программд оруулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, үр дүнг шийдвэр гаргагчдад мэдээлэх, тайлан бичих, хэвлэн нийтлүүлэх талаар мэргэжил, аргазүйн сургалтыг тасралтгүй зохион байгуулна.

3.3.12. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох доод шатны байгууллагыг мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний тандалт шинжилгээний мэдээллээр тасралтгүй хангана.

3.3.13. Жил тутамд Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжтэй хамтран 5 Мал эмнэлгийн газар, лабораторийн халдварт өвчний тандалтын шинжилгээнд биечлэн хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллана.

3.3.14. Мал, амьтны халдварт өвчний тандалтын арга, аргачлал боловсруулах, тандалт зохион байгуулах, үр дүнг хэвлэн нийтлүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллагууд, салбар хоорондын байгууллагуудтай хамтран ажиллана.

3.3.15. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийн үед шаардлагатай тохиолдолд халдварт өвчний голомтод ажиллах шуурхай хариу арга хэмжээний багт лабораторийн мэргэжилтэнг томилон ажиллуулна.

#### **3.4. Мал эмнэлгийн газрын халдварт өвчний тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of aimag and capital VSs on surveillance activities)**

3.4.1. Улсын тандалтын төлөвлөгөөтэй уялдуулан аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх малын эрүүл мэндийн тандалтын төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан боловсруулж, Мал эмнэлгийн газрын дарга батална.

3.4.2. Жилийн төлөвлөгөөнд зорилго, хэлбэр, хамрагдах мэдрэмтгий мал, амьтны



тоо, санхүүжилт, шаардагдах хүний нөөц, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг дэлгэрэнгүй тусгана.

3.4.3. Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс тандалт шинжилгээний сорьц цуглуулах, шинжилгээ хийх, шаардлагатай үед Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид илгээж баталгаажуулах, тээвэрлэх болон оношлуурын зардлыг байгууллагын төсөвт тусган шийдвэрлүүлнэ.

3.4.4. Мал, амьтны халдварт өвчний 5-10 жилийн өвчлөл, хорогдлын мэдээнд үндэслэн тандалт шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтооно. Тэргүүлэх чиглэлийн халдварт өвчнийг тандалтад хамруулах саналыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

3.4.5. Харьяалах засаг захиргаа, салбар хоорондын байгууллагуудыг мал, амьтны халдварт өвчний тандалтын мэдээллээр тогтмол хангаж, хамтран ажиллах, орон нутгийн хэмжээнд зайлшгүй хэрэгжүүлэх халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний талаар засаг захиргааны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлнэ.

3.4.6. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлтийн үед засаг захиргаа, салбар хоорондын байгууллагуудыг нөхцөл, байдлын мэдээллээр тогтмол хангаж, хамтран ажиллана.

3.4.7. Мал эмнэлгийн тасгийн тандалтын багийг халдварт өвчний дэгдэлтийн үед бие даан судалгаа хийх, дүгнэлт гаргах, шуурхай хариу арга хэмжээ авах, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, аж ахуйн нэгж (махны үйлдвэр, нядалгааны газар, малын зах, мах болон дайвар бүтээгдэхүүн худалдаалдаг хүнсний зах)-малын эмчийг халдварт өвчний сэжигтэй тохиолдол, сэжиг бүхий бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд мэдээлэх, шуурхай хариу арга хэмжээ авах аргад тасралтгүй сургана.

3.4.8. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийн үед шаардлагатай тохиолдолд халдварт өвчний голомтод ажиллах шуурхай хариу арга хэмжээний багийг томилон ажиллуулна.

### **3.5. Мал эмнэлгийн газрын тандалтын багийн гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the Surveillance team of aimag and capital VSs on surveillance activities)**

3.5.1. Тандалтын багт хамаарах гишүүн тус бүрийн тандалтын үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг нарийвчлан тодорхойлж, Мал эмнэлгийн газрын даргаар батлуулна. Тандалтын багийн ахлагч тандалтын ерөнхий төслийг боловсруулж, багийн гишүүдээр хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

3.5.2. Харьяа Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс мал, амьтны гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг өдөр тутамд, бусад халдварт өвчний батлагдсан тохиолдлын мэдээг сар бүрийн 30-ны өдрөөр

тасалбар болгон цуглуулж, дүн шинжилгээ хийн, гоц халдварт болон бусад халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.3. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын мэдээг Мал эмнэлгийн тасгаас тухай бүр хүлээн авч, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжид 2 цагийн дотор 261601 утас болон [survey@vet.gov.mn](mailto:survey@vet.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ. Хүлээн авсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох Мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархварзүйч, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмчийг мэргэжил, арга зүйн зөвлөмж, эргэн мэдээллээр тасралтгүй хангана.

3.5.4. Харьяа Мал эмнэлгийн тасгаас мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй өвчнөөр олон мал, амьтан өвчилсөн талаарх мэдээлэл ирсэн тухай бүр нь Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжид 2 цагийн дотор 261601 утас болон [survey@vet.gov.mn](mailto:survey@vet.gov.mn) цахим хаягаар мэдээлнэ. Холбогдох тасгийн байцаагч, тархварзүйчид хэрэгжүүлэх шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, хамтран ажиллана.

3.5.5. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг давтамжтайгаар хэрэгжүүлж, сэжигтэй тохиолдол илэрсэн үед тандалтын мэдээнд тухай бүр дүн шинжилгээ хийж, мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах, Мал эмнэлгийн тасгийн тандалтын багийг эргэн мэдээлэл, мэргэжил, аргазүйн зөвлөмжөөр тасралтгүй хангах, мэдээ ирүүлэлтийн байдалд хяналт тавих зэрэг ажлыг гүйцэтгэнэ. Илрүүлсэн сэжигтэй тохиолдлын оношийн баталгаажилтын байдалд хяналт тавьж, дүгнэлт хийнэ.

3.5.6. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт, эпидемийн үед холбогдох Мал эмнэлгийн тасгийн тандалтын багаас мал, амьтны өвчлөл, хорогдол, хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг өдөр тутамд ... хаягаар цахимаар авч, дүн шинжилгээ хийж, шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил, аргазүйн зөвлөмжөөр тогтмол хангах, үр дүнг эргэн мэдээлэх, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна.

3.5.7. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын мэдээг Мал эмнэлгийн тасгийн тандалтын багаас сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон ... хаягаар цахим хэлбэрээр авч, мэдээнд хяналт тавьж, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгжид ... хаягаар цахимаар хүргүүлнэ. Мал эмнэлгийн тасгийн тандалтын багаас ирүүлсэн мэдээлэлд сар бүрийн эхний 7 хоногт багтаан дүн шинжилгээ хийж, Мал эмнэлгийн газрын удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд, засаг захиргаа, Мал эмнэлгийн тасгийн тандалтын багийн ахлагчид цахим хэлбэрээр эргэн мэдээлнэ. Эргэн

мэдээлэлд аймаг, нийслэлийн хэмжээнд халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх аргын талаар саналыг тусгана.

3.5.8. Мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын аймаг, нийслэлийн хэмжээний тоон мэдээнд сар, улирал, хагас жил, жил тутамд дүн шинжилгээ хийж, Мал эмнэлгийн газрын удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд, засаг захиргаа, Мал эмнэлгийн тасгийн тандалтын багийн ахлагчийг эргэн мэдээллээр тасралтгүй хангана.

3.5.9. Мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын олон жилийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, өвчин тус бүртэй тэмцэх, сэргийлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх, өвчлөлийн босго үзүүлэлт, хэтийн хандлагыг тооцох, тэргүүлэх чиглэл тогтоох замаар халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг зөв төлөвлөх, тохирсон хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ашиглана.

3.5.10. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор харьяа аймаг, нийслэлийн хэмжээнд үйл явдалд суурилсан тандалтын мэдээллийг цуглуулж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5.11. Харьяа Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн тандалтын багт жилд 2-оос доошгүй удаа журмын хэрэгжилтэд явцын хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангана.

### **3.6. Мал эмнэлгийн тасгийн тандалтын багийн гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the Surveillance team of soum and district VSs on surveillance activities)**

3.6.1. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед Мал эмнэлгийн газрын тандалтын багт 2 цагийн дотор утас болон хаягаар цахимаар мэдээлнэ.

3.6.2. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж хийж, мэдээллийг Мал эмнэлгийн нэгдсэн системд оруулж байгаа эсэхэд хяналт тавих, оруулсан мэдээллийг баталгаажуулах, сэжигтэй тохиолдол бүрийг харьяа Мал эмнэлгийн газрын тандалтын багт 2 цагийн дотор утас болон цахимаар мэдээлнэ.

3.6.3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, аж ахуйн нэгжийн малын эмчээс мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй өвчнөөр олон мал, амьтан өвчилсөн талаарх мэдээлэл ирсэн тухай бүр харьяа Мал эмнэлгийн газрын тандалтын багт 2 цагийн дотор утас болон цахимаар мэдээлнэ. Холбогдох аж ахуйн нэгжийн

малын эмчид хэрэгжүүлэх шуурхай хариу арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, хамтран ажиллана. Харьяалах Мал эмнэлгийн газрын тандалтын багийн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээг зохион байгуулна.

3.6.4. Мал, амьтны гоц халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн үед голомтод ажиллаж буй шуурхай хариу арга хэмжээний багаас мал, амьтны өвчлөл, хорогдол, хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний мэдээ, мэдээллийг өдөр тутамд цахимаар авч, харьяалах Мал эмнэлгийн газрын тандалтын баг, шийдвэр гаргагчдыг мэдээллээр тасралтгүй хангана. Шуурхай хариу арга хэмжээний багаас өдөр тутамд ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр тогтмол хангана. Шаардлагатай тохиолдолд халдварт өвчний голомтод ажиллаж, шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулна.

3.6.5. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн үед хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлыг засаг захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

3.6.6. Харьяа сум, дүүрэгт бүртгэгдсэн мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын мэдээг сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон Мал эмнэлгийн газрын тандалтын багт цахимаар хүргүүлнэ. Мэдээлэлд сар бүрийн эхний 7 хоногт багтаан дүн шинжилгээ хийж, сум, дүүргийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд, холбогдох аж ахуйн нэгжийн мал эмч нар т цахим хэлбэрээр эргэн мэдээлнэ.

3.6.7. Харьяа сум, дүүрэгт бүртгэгдсэн мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын тоон мэдээнд сар, улирал, хагас жил, жил тутамд дүн шинжилгээ хийж, засаг захиргааны нэгжийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүд, нэгжийн мал эмч нарыг эргэн мэдээллээр тасралтгүй хангана. Эргэн мэдээлэлд харьяа сум, дүүрэгт халдварт өвчний тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх аргын саналыг тусгана.

3.6.8. Харьяа сум, дүүрэгт бүртгэгдсэн мал, амьтны халдварт өвчний батлагдсан тохиолдлын өвчлөл, хорогдлын олон жилийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж, өвчин тус бүртэй тэмцэх, сэргийлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлэх, тэргүүлэх чиглэлийг тогтоох, тэмцэх, сэргийлэх арга хэмжээг зөв төлөвлөх, тохирсон хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ашиглана.

3.6.9. Мал, амьтны халдварт өвчний дэгдэлтийг эрт илрүүлэх, шуурхай хариу арга хэмжээ авах зорилгоор харьяа сум, дүүргийн хэмжээнд үйл явдалд суурилсан тандалтын мэдээллийг цуглуулж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.6.10. Харьяа нэгж, хувийн хэвшлийн лаборатори, холбогдох аж ахуйн нэгжийн тандалтын багт ажиллагсадыг мал, амьтны халдварт өвчний тандах, тандалтын

мэдээ, мэдээлэл цуглуулах, тохиолдлыг мэдээлэх, тандалтын үед сорьц цуглуулах, дэгдэлтийн судалгаа хийх талаар сургалтад тогтмол хамруулна.

### **3.7. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (ерөнхий болон төрөлжсөн мал эмнэлэг, хилийн цэргийн мал эмнэлгийн) малын эмчийн гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the private veterinary clinic on surveillance activities)**

3.7.1. Нэгжийн малын эмч нь харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд илэрсэн мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг Мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархварзүйчид мэдээлэл авснаас хойш 2 цагийн дотор мэдээлж, байцаагч, тархварзүйчийн зөвлөсний дагуу шуурхай хариу арга хэмжээг хамтран зохион байгуулна.

3.7.2. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалт хийж, илэрсэн сэжигтэй тохиолдол бүрийг харьяа мал эмнэлгийн хяналтын байцаагчид 2 цагийн дотор мэдээлнэ.

3.7.3. Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчинтэй холбоотой сэжигтэй тохиолдол гарч байгаа талаарх албан бус мэдээлэл, цуу яриа зэргийг малчидтай холбогдон тодруулж, баталгаажуулан, “сэжигтэй” гэж үзвэл байцаагч, тархварзүйчид 2 цагийн дотор мэдээлнэ.

3.7.4 Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй өвчнөөр олон мал, амьтан өвчилсэн тохиолдолд хяналтын байцаагч, тархварзүйчид 2 цагийн дотор мэдээлнэ. Шуурхай хариу арга хэмжээг харьяа Мал эмнэлгийн тандалтын багтай хамтран хэрэгжүүлнэ.

### **3.8. Эрчимжсэн аж ахуй болон бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж буй малын эмчийн гүйцэтгэх үүрэг (Roles and responsibilities of the Surveillance team of cattle and pig farm, poultry on surveillance activities)**

3.8.1. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед харьяа Мал эмнэлгийн тасгийн хяналтын байцаагч, тархвар зүйчид 2 цагийн дотор утсаар эсвэл холбогдох бусад хэлбэрээр мэдээлнэ.

3.8.2. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг хийж, илэрсэн сэжигтэй тохиолдол бүрийг харьяа Мал эмнэлгийн тасгийн байцаагчид 2 цагийн дотор мэдээлнэ.

3.8.3. Хариуцсан ферм, аж ахуйд мал, амьтан гэнэт олноор үхэж хорогдсон, хээл хаясан эсвэл өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй

өвчнөөр олон мал, амьтан өвчилсөн тохиолдолд сумын Мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархварзүйчид 2 цагийн дотор мэдээлнэ. Шуурхай хариу арга хэмжээг харьяа Мал эмнэлгийн тасгийн тандалтын багтай хамтран хэрэгжүүлнэ.

**3.9. Мал нядалгааны газрууд, хүнсний зах, мал, амьтны худалдаа болон тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ханган нийлүүлэгч байгууллагуудад ажиллаж буй малын эмчийн үүрэг (Roles and responsibilities of veterinarians of meat processing factory, slaughter house, live animal market, meat market and bench-show of live livestock and animals on surveillance activities)**

3.9.1. Худалдаалагдаж буй мал, амьтанд гоц халдварт өвчний сэжигтэй эмнэлзүйн шинж тэмдэг, маханд сэжиг бүхий эмгэг хувирал илэрсэн бол Мал эмнэлгийн тасгийн байцаагч, тархвар зүйчид 2 цагийн дотор утсаар эсвэл холбогдох хэлбэрээр мэдээлнэ.

3.9.2. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг хийж, илэрсэн сэжигтэй тохиолдол бүрийг харьяа Мал эмнэлгийн тасгийн байцаагчид 2 цагийн дотор мэдээлнэ.

**3.10. Тандалтын үйл ажиллагаанд хяналт (мониторинг), үнэлгээ хийх (Routine monitoring and assessment on surveillance activities, criterias for monitoring)**

3.10.1 Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгж нь Мал эмнэлгийн газрын тандалтын багийн үйл ажиллагааг улирал, хагас жил, жил тутамд дор дурдсан шалгуураар хянаж, эргэн мэдээлэл, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангана.

3.10.2. Мал эмнэлгийн газрын тандалтын баг нь сум, дүүргийн тандалтын багийн үйл ажиллагааг улирал, хагас жил, жил тутамд дор дурдсан шалгуураар хянаж, эргэн мэдээлэл, мэргэжил аргазүйн зөвлөмжөөр хангана.

3.10.3. Тандалтын багийн үйл ажиллагааг дор дурдсан шалгуураар хянаж, хэрэгжилтийг хувиар илэрхийлнэ. Тухайн үйл ажиллагааг >90% хэрэгжүүлсэн бол сайн, 70-89% бол хангалттай, <69% хангалтгүй гэж дүгнэнэ. Үүнд:

3.10.3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/16 дугаар тушаалд заасан “Мал, амьтны гоц халдварт өвчнийг мэдээлэх журам”-ын дагуу 2 цагийн дотор дээд шатны байгууллагад мэдээлсэн гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын хувь

3.10.3.1.1. Хоёр цагийн дотор шуурхай хариу арга хэмжээ авч эхэлсэн гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын хувь

3.10.3.2. “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын заавар”-ын дагуу 2

цагийн дотор дээд шатны байгууллагад мэдээлсэн гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын хувь

3.10.3.2.1. “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын заавар”-ын дагуу эрт илрүүлгийн үзлэг, эрсдэлийн үнэлгээний мэдээг сарын бүрийн 30-ны дотор Мал эмнэлгийн нэгдсэн системд баталгаажуулсан хувь

3.10.3.2.2. Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын эргэн мэдээллээр хангагдсан доод шатны тандалтын багийн хувь

3.10.3.2.3. Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын мэдээллээр хангагдсан шийдвэр гаргагчдын хувь

3.10.3.3. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдол, хорогдлын сар бүрийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийсэн хувь

3.10.3.3.1. Сарын мэдээнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг доод шатны тандалтын багийн ахлагчид эргэн мэдээлсэн хувь

3.10.3.3.2. Сарын мэдээнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг шийдвэр гаргагчид, салбар хоорондын холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлсэн хувь

3.10.3.4. Үйл явдалд суурилсан тандалтын мэдээллийг цуглуулж баталгаажуулсан хувь

3.10.3.5. Тандалтын мэдээллээр илрүүлсэн дэгдэлтийн тоо, үүсгэгчийг лабораториор баталгаажуулсан хувь

3.10.3.6. Халдварт өвчний тандалтын чиглэлээр сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний хувь

#### **3.10.4. Тандалтын үйл ажиллагааг үнэлэх (Assessment on surveillance activities)**

Тандалтын үйл ажиллагааг үнэлэхдээ чанарын судалгааны арга буюу бүлгийн ярилцлага, асуумжийн арга, мөрдөж буй баримт бичгийг үнэлэх зэрэг аргуудыг хавсруулан хийнэ.

3.10.5. Уг журмыг зөрчсөн бол Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг зөрчсөнд тооцно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны ... дүгээр сарын .... -ны өдрийн ..... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## **Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнийг тандах хэлбэрүүд**

1.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгж, Мал эмнэлгийн газар, Мал эмнэлгийн тасаг нь халдварт өвчний тандалтын мэдээ, мэдээлэлд тогтмол дүн шинжилгээ хийж, доод шатны байгууллага, шийдвэр гаргагчдыг эргэн мэдээллээр тасралтгүй хангана.

1.2. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнийг тандахдаа дараах тандалтын хэлбэрүүдээс дангаар болон хослуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

### **2.1. Өвчнийг мэдээлэх тогтолцоогоор тандах**

Мал, амьтны халдварт өвчний сэжигтэй болон батлагдсан тохиолдлын мэдээллийг цуглуулж тандана. Үүнд:

#### **2.1.1. Мал, амьтны гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг тандах**

2.1.1.1. Гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдлын тандалтыг бүх шатны, өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн байгууллага, аж ахуйн нэгж хийж гүйцэтгэнэ.

2.1.1.2. Шүлхий, үхрийн арьс товруутах, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг зэрэг гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол болон эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын 2022 оны А/177 дугаар тушаалаар батлагдсан “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээний тандалтын заавар”-ын дагуу бүх шатны, өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн байгууллага, аж ахуйн нэгж хийж гүйцэтгэнэ.

2.1.1.3. Бүх шатны, өмчийн бүх хэлбэрийн мал эмнэлгийн байгууллага, аж ахуйн нэгж нь мал, амьтны дунд өмнө нь оношлогдож байгаагүй өвөрмөц, онош тодорхойгүй өвчний тохиолдлыг дээд шатны мал эмнэлгийн байгууллагад яаралтай 2 цагийн дотор мэдээлнэ.

#### **2.1.2. Мал, амьтны гоц халдварт өвчний батлагдсан тохиолдлыг тандах**

2.1.2.1. Мал эмнэлгийн газар нь мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдол, үхэл хорогдлын тоон мэдээг сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон Мал эмнэлгийн тасгаас цахимаар авч, нэгтгэн, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тархвар зүйн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ. Мөн Мал эмнэлгийн тасгаас авсан халдварт болон гоц халдварт өвчний өвчлөл, үхэл хорогдлын сарын



мэдээнд дүн шинжилгээ хийж, сар бүр эргэн мэдээллээр хангана. Аймаг, нийслэлийн шийдвэр гаргагчид болон салбар хоорондын холбогдох мэргэжилтнүүдийг сар, улирал, хагас жил, жил тутамд мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний өвчлөл, үхэл хорогдлын мэдээллээр хангаж ажиллана.

2.1.2.2. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тархвар зүйн асуудал хариуцсан нэгж нь мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний батлагдсан тохиолдол, үхэл хорогдлын мэдээ (incidence)-г сар бүрийн 30-ны өдрөөр тасалбар болгон Мал эмнэлгийн газраас цахимаар авч, нэгтгэн дүн шинжилгээ хийж, эргэн мэдээллээр хангана. Мөн МЭЕГ, УМЭАЦТЛ-ийн удирдлага, ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтнүүдийг сар, улирал, хагас жил, жил тутамд мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний өвчлөл, үхэл хорогдлын мэдээллээр хангаж ажиллана.

### **2.1.3. Жил тутамд хийгдэх тандалт**

2.1.3.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас дараах тандалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.3.1.1. Эрх бүхий олон улсын байгууллагаас хүлээн зөвшөөрсөн өвчин, халдваргүй болохыг тогтоосон өвчний тандалт

2.1.3.1.2. Дотооддоо өвчин, халдваргүй болохыг хүлээн зөвшөөрч баталгаажуулсан болон баталгаажуулах халдварт өвчний тандалт

2.1.3.1.3. Олон улсын худалдаанд хориг саад үүсгэх эрсдэл бүхий мал, амьтны өвчин, халдвар, малын гаралтай бүтээгдэхүүн,

2.1.3.1.4. Тусгайлан баталсан стратеги төлөвлөгөө, бодлого бүхий малын өвчин, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн,

2.1.3.2. Мал эмнэлгийн газар нь дээрх тандалтыг хэрэгжүүлэхээс гадна орон нутгийн хэмжээнд дараах тандалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ.

2.1.3.2.1. Орон нутгийн хэмжээнд тодорхой нэрийн халдварт өвчин, халдваргүйг нотлох тандалт,

2.1.3.2.2. Тодорхой нэрийн халдварт өвчнөөр статус авсан бол статусыг нотлох тандалт,

### **2.2. Үйл явдалд суурилсан тандалт (Event based surveillance)**

2.2.1. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд нь бүх түвшиндээ мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, FM радио), шар хэвлэл, мэдээллийн сайт, фейсбүүк, твиттер, инстаграмаас мал, амьтны өвчлөл, үхэл хорогдол, сэг зэмийн талаарх албан ба албан бус мэдээллийг өдөр тутамд шүүж, хамаарал бүхий мал эмнэлэг болон бусад байгууллагатай холбогдон, мэдээллийг тодруулан, хариу өгч ажиллана.

2.2.2. Үйл явдалд суурилсан тандалтын мэдээллийг баталгаажуулахад мал, амьтны гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол, халдварт өвчин дэгдсэн болох нь тогтоогдвол дээд шатны мал эмнэлгийн байгууллагад 2 цагийн дотор мэдээлж,

хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### **2.3. Агшингийн судалгааны загварт суурилсан тандалт (surveys)**

Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын өвчний тандалт, судалгаа хариуцсан нэгж, УМЭАЦТЛ нь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага болон зоонозын халдварын үед салбар хоорондын байгууллагын саналыг тусган, тандалтын арга, аргачлалыг боловсруулж, тандалтыг зохион байгуулна.

Агшингийн судалгааны загварт суурилсан тандалтыг дараахь зорилгоор хийнэ. Үүнд:

2.3.1. Дотооддоо өвчин, халдваргүй болохыг баталгаажуулах зарим халдварт өвчний тархалт (халдварлалтын түвшин)-ыг мэдрэмтгий мал, амьтны дунд ийлдэс судлал, молекул биологийн аргаар тогтоох, үүсгэгчийг судлах, тухайн халдварт өртөх эрсдэлт хүчин зүйлсийг судлах зорилгоор тодорхой давтамжтай хийнэ.

2.3.2. Дархлаажуулалтын дараа мэдрэмтгий мал, амьтны вакцины хамралт, дархлал тогтоцын түвшин, дархлааны идэвхийг шалгахад ашиглана.

2.3.3. Тандалтын үйл ажиллагаанд оролцож буй бүх шатны байгууллагууд, малын эмч, мэргэжилтнүүдийн чадавх, малчдын халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг мэдээлэх талаар мэдлэг, дадал, хандлагыг тодорхой давтамжтай үнэлэхэд ашиглана.

#### **2.3.4. Түүврийн хэмжээг тооцох, түүвэрлэх арга (Sample size and sampling for surveys)**

- Түүврийн хэмжээг тооцох, түүвэрлэхдээ нэг малчин өрх эсвэл хот айл, нэг аж ахуйн нэгжид байгаа сүрэг мал, амьтныг нэг тархвар зүйн нэгж (түүвэрлэлтийн нэгж) гэж үзнэ.
- Тандалтын зорилго, төсөв зардал, өвчин үүсгэгчийн онцлог, улиралчлал, хамруулах мал, амьтны маллагааны хэлбэр зэргээс хамаарч түүврийн хэмжээг дараахь байдлаар тооцно. Үүнд:

##### **2.3.4.1. Магадлалт түүвэрлэлт (probability-based sampling) хийх**

- Тандалтад хамруулах мал, амьтныг санамсаргүйгээр сонгоно.
- Магадлалт түүвэрлэлт хийсэн тохиолдолд тандалтын үр дүн нь улсын хэмжээний мэдрэмтгий мал, амьтныг бүрэн төлөөлөхүйц байна.

##### **2.3.4.1.1. Энгийн санамсаргүй түүвэрлэлт (Simple randomization):**

- Өмнө нь хийгдсэн судалгаа эсвэл тандалтын дүнд үндэслэн агшингийн судалгаанд түүвэр тооцох томъёогоор түүврийн хэмжээг 95%-ийн үнэн магадтай, 5%-ийн алдаатайгаар тооцно.

- Тандалтад хамруулах нэгж, мал, амьтныг сонгохдоо энгийн болон системчилсэн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгоно.

#### **2.3.4.1.2. Олон үет багцалсан түүвэрлэлт (Multistage cluster sampling):**

- Агшингийн судалгааны олон үет багцалсан түүвэрлэлтийн аргыг ашиглан, судалгаанд хамруулах аймаг, сум, баг, аж ахуйн нэгж эсвэл өрх, мал, амьтны тоог тооцно.
- Олон тооны нэгжийг судалгаанд хамруулах нь тархалт тооцоход үр дүнтэй. Тандалтад хамруулах тархвар зүйн нэгжийг санамсаргүйгээр сонгоно.

#### **2.3.4.2. Магадлалт бус түүвэрлэлт (Non-probability sampling) хийх**

- Тандалтыг богино хугацаанд бага зардлаар хийх шаардлага гарсан, халдварт өвчний дэгдэлт бүртгэгдсэн, зэрлэг амьтдыг тандалтад хамруулах үед магадлалт бус түүвэрлэлтийн аргыг сонгоно.
- Магадлалт бус түүвэрлэлт хийж байгаа нөхцөлд түүврийн хэмжээг тооцохгүй, тандалтад хамруулах мал, амьтныг санамсаргүйгээр сонгохгүй тул энэ төрлийн түүвэрлэлтийн үр дүн нь улсын хэмжээний мэдрэмтгий мал, амьтныг бүрэн төлөөлөхгүй. Зөвхөн тухайн тандалтад хамруулсан мал, амьтанд хамаарна.
- Магадлалт бус түүвэрлэлт хийхдээ тандалтад хамруулах мал, амьтныг дараахь байдлаар сонгоно. Үүнд:

2.3.4.2.1. Тандалтын зорилгоос хамаарч (convenience) тандалтад хамруулах мал, амьтны тоо, түүвэрлэх аргыг тогтооно.

2.3.4.2.2. Мэргэжилтнүүдийн санал (expert choice)-аар түүвэрлэх: тандалтад хамруулж буй өвчний тархвар судлалын нөхцөл байдлаас хамаарч, мэргэжилтнүүд, шинжээч, судлаачдын санал, зөвлөмжид үндэслэн тандалтад хамруулах мал, амьтны тоо, түүвэрлэх аргыг тогтооно.

2.3.4.2.3. Тооны харьцаа (quota)-аар түүвэрлэх: мал, амьтныг тандалтад хамруулахдаа насны бүлэг, үржлийн хэлбэр, хүйс гэх мэт үзүүлэлтийн аль нэгийг сонгож, тэнцүү тоогоор хамруулна.

2.3.4.2.4. Эрсдэлд өртсөн байдлаар түүвэрлэх: халдварт өвчний дэгдэлтийн үед өвчтэй мал, амьтантай нэг хот, аж ахуй эсвэл нэг бэлчээр, усны эх үүсвэртэй гэх мэт эрсдэлд өртсөн байдлаар түүвэрлэж, тандалтад хамруулна.

#### **2.4. Төхөөрөлтийн өмнөх ба дараахь хяналтын үзлэг, шинжилгээ (Ante-mortem and post-mortem inspections)**

2.4.1. УМЭАЦТЛ нь аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори ба хувийн хэвшлийн лабораторийн шинжилгээний мэдээллээс баталгаажуулах тандалтад хамаарах өвчний тохиолдлыг илрүүлж, мөшгөн судална.

2.4.2. Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори нь харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улс ба хувийн хэвшлийн лабораториудын шинжилгээний мэдээллээс баталгаажуулах тандалтад хамаарах өвчний тохиолдлыг илрүүлж, мөшгөн судална.

2.4.3. Махны үйлдвэр, мал нядалгааны газар, малын зах, мах худалдаалдаг хүнсний зах, малын үзэсгэлэн худалдаанд ажиллаж буй малын эмч нь хариуцсан үйлдвэр, зах, нядалгааны газарт төхөөрөлтийн өмнөх ба дараахь хяналтын үзлэг хийж, халдварт өвчний сэжиг бүхий мал, амьтан болон бүтцийн эмгэг хувирал бүхий бүтээгдэхүүн илэрсэн тохиолдолд гарал үүслийг сайтар нягтлан, бүртгэж, харьяа тасгийн байцаагчид 2 цагийн дотор мэдээлнэ. Тандалтаар тухайн долоо хоногт халдварт өвчний сэжигтэй тохиолдол илрээгүй бол “тэг тохиолдол”-ын мэдээг долоо хоног бүрийн Даваа гариг бүрт харьяа тасгийн байцаагчид өгнө.

## **2.5. Зэрлэг амьтдын дунд хийх тандалт (Wildlife surveillance)**

Зэрлэг амьтдын дунд мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчнийг дараахь хэлбэрээр тандана. Үүнд:

2.5.1. Аймаг, нийслэлийн МЭГ, сум, дүүргийн МЭТ, МЭҮН нь харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд үйл явдалд суурилсан тандалтаар зэрлэг амьтдын өвчлөл, үхэл хорогдол, сэг зэмийн талаарх мэдээллийг цуглуулж, шалган баталгаажуулж, нотолно. Мэдээллийг баталгаажуулахад мал, амьтны гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол болох нь тогтоогдвол дээд шатны мал эмнэлгийн байгууллагад 2 цагийн дотор мэдээлж, хариу арга хэмжээг авна.

2.5.2. УМЭАЦТЛ нь мэдрэмтгий зэрлэг амьтдаас сорьц, эмгэгт материал цуглуулж, халдварт болон гоц халдварт өвчний халдварлалт, үүсгэгчийг тандан судална. Шаардлагатай тохиолдолд зэрлэг амьтдыг судлах байгууллагатай хамтран ажиллана.

2.5.3. Аймаг, нийслэлийн МЭГ, сум, дүүргийн МЭТ, МЭҮН нь харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд МЭЕГ, УМЭАЦТЛ-иос зэрлэг амьтдын дунд хийгдэх тандалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

## **2.6. Зоонозын халдварт өвчний салбар хоорондын хамтарсан тандалт (Intersectoral joint surveillance)**

2.6.1. МЭЕГ, УМЭАЦТЛ нь үндэсний түвшинд ЗӨСҮТ, ХӨСҮТ, МЭХ-тэй хамтран зоонозын зарим халдварт өвчний тандалтыг мал, амьтан, хүн амын дунд нэгдсэн арга, аргачлалаар хийж, үр дүнг хамтран тайлагнах, хэвлэн нийтлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.6.2. Аймаг, нийслэлийн МЭГ, сум, дүүргийн МЭТ, МЭҮН нь харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд салбар хоорондын хамтарсан тандалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

## **2.7. Нийтийн эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг тандалтад ашиглах (Use**

## **public health data)**

Бүх түвшний улс ба хувийн мал эмнэлгийн байгууллагууд нь хүний өвчлөл, уур амьсгал, хүрээлэн буй орчны мэдээлэлд үндэслэн баталгаажуулах тандалтад хамаарах мал, амьтны зоонозын халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж байгаа эсэхийг тандана.